

6-Р АНГИЙН ТҮҮХ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

“А” ХУВИЛБАР

1. Түүхийн эх сурвалжийн ангиллаас зөвийг сонгоно уу?
 - a. Бичгийн, Эд өлгийн Аман
 - b. Бичгийн , Эд өлгийн, Сурвалжийн
 - c. Эд өлгийн, Аман, Түүвэр
 - d. Бичгийн, эд өлгийн, Археологийн
2. Чулуун зэвсгийн үеийг түүхийн шинжлэх ухаанд хэрхэн үечилдэг вэ?
 - a. Палеолит, Мезолит, Неолит
 - b. Хуучин үе, Дунд үе, Шинэ үе
 - c. Түүвэрлэх үе, Мал аж ахуйн үе, Технологийн үе
 - d. Эртний үе, Дундад зууны үе, Шинэ үе, Орчин үе
3. Дэлхий нийтэд түгээмэл хэрэглэж буй он тооллын 1 оноос хойш өнөөдрийг хүртэлх хугацааг _____ гэнэ.
 A. НТӨ В. НТ С. Зуун D. Мянган E. Хижрийн тоолол
4. 3.5 сая жилийн өмнө амьдарч байсан хүний яс хаанаас олдсон бэ?

A. Ази тивээс олдсон.	B. Австрали тивээс олдсон.
C. Америк тивээс олдсон.	D. Африк тивээс олдсон.
5. Монгол нутагт 800000 жилийн тэртээ хүн амьдарч байсныг илтгэх ул мөр аль аймгийн хаанаас олдсон бэ?

A. Баянхонгор аймгийн Баянлиг сумын цагаан агуй	B. Баянхонгор аймгийн Өлзийт сумын Нарийн голын бууц суурин	C. Өмнөговь аймгийн Ярх уул	D. Өвөрхангай аймгийн Мойлтын амын бууц суурин
---	---	-----------------------------	--
6. гэдэг нь зураг чимэглэл сийлсэн бичээс бүхий босоо чулуун хөшөө.

A. Гэрэлт хөшөө	B. Буган чулуун хөшөө	C. Хүн чулуун хөшөө
-----------------	-----------------------	---------------------
7. Чулуугаар анх багаж зэвсэг хийж чаддаг болсон хүнийг юу гэж нэрлэдэг вэ?

A. Босоо явагч хүн	B. Чадварлаг хүн
C. Оюун ухаант хүн	D. Орчин үеийн хүн
8. “Неолит” гэдэг нь чулуун зэвсгийн аль үеийг нэрлэж байна вэ?

a. Шинэ чулуун зэвсэг	c. Дунд чулуун зэвсэг
b. Хуучин чулуун зэвсэг	d. Хүрэл зэвсэг
9. Эртний хүмүүс нэг газар удаан хугацаагаар сууршин амьдрах болсон шалтгаан аль нь вэ?
 - a. Газар тариаланд шилжсэнээр
 - b. Гар урлал хөгжсөнөөр
 - c. Мал аж ахуйд шилжсэнээр
 - d. Төмөрлөг боловсруулалт хөгжсөнөөр
10. Хүмүүс байгальд буй бэлэн үр жимсийг түүж идэхээ больж түүний заримыг тарьж ургуулах болжээ. Энэ нь аль үед хамаарах вэ?

a. Шинэ чулуун зэвсгийн үе	c. Дунд чулуун зэвсгийн үе
----------------------------	----------------------------

b. Хуучин чулуун зэвсгийн үе

d. Хүрэл зэвсгийн үе

11. Аль нь Монгол нутаг дахь нүүдэлчдийн дурсгал биш вэ?
A. Буган чулуун хөшөө B. Дөрвөлжин булш C. Хиргисүүр D. Пирамид
12. Нүүдэлчид нас барсан хүнээ дөрвөлжин хэлбэрийн хашлага чулуу бүхий байгуулламжинд оршуулдаг байжээ. Тухайн байгууламжийн нэр юу вэ?
A. Хиргисүүр B. Буган хөшөө C. Булш D. Дөрвөлжин булш
13. Евразийн хээр талаас 800 орчим буган хөшөө олддоод байна. Эдгээрээс хэд орчим нь монгол улсын нутгаас олдсон бэ?
A. 600 B. 550 C. 700 D. 300
14. Ур хот мянган иргэнтэй .
A. 50000 B. 30000 C. 42000 D. 24000
15. НТӨ10000 оны үед дэлхийн хүн ам 4 сая орчим байсан бол НТӨ 5000 он гэхэд 5 сая шахам хүнтэй болжээ. Хүн ам өсөхөд нөлөөлсөн гол хүчин зүйлийг сонгоно уу.
A. Гар урлал хөгжсөн. B. Газар тариаланд шилжсэн.
C. Мал аж ахуйд шилжсэн. D. Олзворлох, аж ахуй хөгжсөн
16. Эртний хүмүүс анх,,,, мөрний дагуу суурьшиж байсан.
A. Тигр, евфат, нил, инд мөрөн, шар мөрөн
B. Тигр, евфат, нил, инд мөрөн, энэтхэгийн далай
C. Тигр, атлант, нил мөрөн, инд мөрөн, номхон далай
D. Тигр, шинжян, нил мөрөн, инд мөрөн, номхон далай мөрөн
17. Одоо мэдэгдэж буйгаар дэлхийн хамгийн эртний ваар _____ үүсчээ. Харин _____ дэлхийн хэд хэдэн газар ваар сав хийдэг болсон.
A. Хятад, НТӨ 6000 оны орчим B. Япон, НТӨ 7000 оны орчим
C. Египет, НТӨ 5000 оны орчим D. Энэтхэг, НТӨ 4000 оны орчим
18. Анхны бичиг үүссэн хаана хэзээ үүссэн бэ?
A. Энэтхэгт НТӨ 5000-5100 оны үед B. Шүмэрт НТӨ 3200-3100 оны үед
C. Хятадад НТӨ 4000-4100 оны үед D. Египетэд НТӨ 2000-2001 оны үед
19. Аль нь хүн төрөлхтний суурин иргэншил үүссэн уугуул нутаг биш вэ?
a. Тигр, Евфрат c. Нил
b. Амазон d. Шар мөрөн
20. Хүн төрөлхтний анхны бичгийг юун дээр бичдэг байсан бэ?
a. Цаас b. Хулс c. Шавар d. Элс
21. Инд мөрний хөндийд анх бий болсон хотууд аль нь вэ?
a. Тенис, Мемфис c. Ур, Урук
b. Хараппа, Мохенжо-Даро d. Фив, Ниппур
22. Эртний Хятадын иргэншил ямар мөрний хөндийг даган үүссэн бэ?
a. Инд мөрөн c. Тигр, Евфрат мөрөн
b. Шар мөрөн d. Хөх мөрөн
23. "Месопотоми" гэж ямар мөрнүүдийн хөндийг нэрлэдэг вэ?
a. Инд мөрөн c. Тигр, Евфрат мөрөн
b. Шар мөрөн d. Хөх мөрөн
24. Дэлхий дээр анх удаа цемент цутган барилга барьсан улс аль нь вэ?
a. Грек b. Ром c. Хятад d. Египет
25. Нил мөрний эрэг дагуу эртний ямар улс байгуулагдсан бэ?
a. Энэтхэг улс c. Хятад улс
b. Египет улс d. Ассир улс

26. Эртний Грект газар тариалан эрхлэх боломжгүй болсон шалтгаан аль нь вэ?
- A. Байгалийн эрс тэс уур амьсгалтай байсан учир
 - B. Газар нутаг хомсдолтой байсан учир
 - C. Хэтэрхий уулархаг, хадархаг байсан учир
 - D. Нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг байсан учир
27. Ромын хаант улсын үед том газар эзэмшигчид гэгдэх хүн амын тодорхой хэсгийг бүрдүүлж байсан Патрицууд гэсэн тодорхойлолтод аль нь орох вэ?
- a. Ром хотын суурийг тавьсан язгууртанууд, том газар эзэмшигчид
 - b. Тариачид малчид, гар урчууд, жижиг газар эзэмшигчид
 - c. Ахмадын зөвлөлийн гишүүд
 - d. Сурган хүмүүжүүлэгчид
28. “Эрчүүд нь эмэгтэйчүүдэд хүндэтгэлтэй хандах ёстой ч эмэгтэйчүүд гэртээ эрчүүдийн хүслээр амьдрах ёстой” хэмээн ямар хуульд заасан байдаг вэ?
- A. Манугийн хууль
 - B. Хаммурапи хааны хууль
 - C. 12 Зэс самбарын хууль
 - D. Их засаг хууль
29. Хүннүүд яагаад мал аж ахуйг голлон эрхлэх болсон бэ?
- a. Мал амьтан элбэг байсан учраас
 - b. Байнгын дайн тулаан хийж байсан учраас
 - c. Өвөг дээдсийнхээ уламжлалыг дагасан учраас
 - d. Байгаль, газарзүйн онцлогоос хамаарч байсан учраас
30. Түрэг угсааны улсуудын ноёрхлын үед Монголчуудын өвөг дээдэс ямар нэртэй газарт нутаглаж байсан хэмээн домоглодог вэ?
- a. Хөвсгөлийн уулсад
 - b. Алтайн нуруунд
 - c. Хөлөнбуйрт
 - d. Эргүнэ гүнд
31. Монгол угсааны Сяньби улсыг хэн, хэзээ үндэслэн байгуулсан бэ?
- a. Таньшихуай НТ 141 он
 - b. Шэлунь НТ 235 он
 - c. Таньшихуай НТ 156 он
 - d. Мугулюй НТ 181 он
32. Хүннү гүрний талаарх ойлголтоос хамааралгүйг нь сонгоно уу?
- a. Хүннү “амьтаны загварт ” урлаг өндөр түвшинд хөгжсөн.
 - b. Хүннүгийн оршуулгын дурсгалуудын нэг нь Ноён уулын дурсгал юм.
 - c. Хүннү гүрний зүүн талд Юэжи, Усунь зэрэг аймгууд оршиж байв.
 - d. Хүннүгийн үеэс эрийн гурван наадам үүсчээ.
33. Хятадын эртний сурвалж бичигт “ тэдний зэвсэг хурц, морины хурдан нь Хүннү нарынхаас нэн хэтийджээ ” хэмээн өгүүлсэн нь ямар улсыг өгүүлж байна вэ?
- a. Нирун
 - b. Сяньби
 - c. Хятан
 - d. Хүннү
34. Монгол нутагт байгуулагдсан Монгол угсааны эртний улсаас хамгийн сүүлд байгуулагдсан улс аль нь вэ?
- a. Хүннү
 - b. Сяньби
 - c. Нирун
 - d. Хятан

35. Сяньби улс “үхрийн эврэн нум, алт мөнгөн эдлэл ангийн үс нэхийгээр хийсэн дээлээр алдартай” гэсэн нь ямар утга санааг илэрхийлж байна вэ?

- a. Үнэт эдлэлийн худалдаа хөгжсөн
- b. Гар урлал хөгжсөн
- c. амьтаны загварт урлаг хөгжсөн
- d. Харилцаа холбоо хөгжсөн

36. Эртний улсуудыг соёлын ойлголтуудтай нь зөв тохируулна уу.

- | | |
|------------|----------------------|
| 1. Хятад | А. Упанишад |
| 2. Энэтхэг | В. 12 самбарын хууль |
| 3. Ром | С. Амфи театр |
| 4. Грек | Д. Цайны соёл |

a. 1B 2A 3C 4D c. 1D 2A 3C 4B

b. 1D 2A 3B 4C d. 1C 2B 3A 4D

37. Хүний хөдөлмөрийн багаж зэвсгийн хөгжлийн хамрах хугацааг зөв харгалзуулна уу.

- | | |
|----------|--|
| A. Чулуу | 1. НТӨ 6000-5000 жил, бага хэмд хайлдаг уян хатан зөөлөн |
| B. Зэс | 2. НТӨ 1200 оны орчим, өндөр хэмд хайлдаг, хатуу бат бөх чанар |
| C. Хүрэл | 3. Палеолит, неолит, байгалийн чулуу |
| D. Төмөр | 4. НТӨ 4500-4000 оны орчим, зэс, цагаан тунгалагийн холимог |

A. A 3 B 2 C 3 D 1 B. A 2 B 1 C 4 D 3

C. A 4 B 3 C 2 D 1

D. A 1 B 2 C 3 D 4

E. A 3 B 1 C 4 D 2

38. Эртний хүмүүсийн хөгжлийн үйл явцыг зөв харгалзуулна уу?

- | | |
|---|-------------------------------|
| a. Ан агнах ургамал түүхэд хэрэглэхийн тулд | 1. Хэл зохиов |
| b. Ан агнах шинэ газар нутаг хайхын тулд | 2. Газар нутагт тархан нүүдэг |
| c. Харилцах шаардлагатай байсан тул | 3. Багаж зэвсэг хийдэг байв. |
| d. Араатнаас биеэ хамгаалж хүнс хоол олж идэхийн тулд | 4. Овгоороо амьдардаг байв. |

A. 1c 2 a 3b 4 d

в. 1a 2d 3c 4b

с. 1b 2a 3b 4d

39. Дараах түүхэн өөрчлөлтүүдийг тохирох улстай нь харгалзуулаарай

- | | |
|--------------------------|-------------|
| a. Хаммурапи хааны хууль | 1. Энэтхэг |
| b. Муми | 2. Хятад |
| c. Кастийн тогтолцоо | 3. Вавилион |
| d. Цагаан хэрэм | 4. Египет |

A. 1a 2d 3b 4c

в. . 1c 2d 3a 4b

с. . 1d 2b3c4a

40. Өөрийн төрсөн оныг жарны тоололд шилжүүлээрэй / 2 оноо /

6-р ангийн бүлгийн сурагч

Авбал зохих оноо

Авсан оноо

Хувь

6-Р АНГИЙН “ТҮҮХ” ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

“В” ХУВИЛБАР

1. Есүс Христийн мэндэлсэн өдрөөс он тооллыг эхлэн тоолох болсноор түгээмэл тоолол бий болсон. Энэ тооллыг бид ямар тоолол гэж нэрлэдэг вэ?
 - a. Аргын тоолол
 - b. Жарны тоолол
 - c. Билгийн тоолол
 - d. Хижрийн тоолол
2. Түүхийн сурвалжийн ангилсан ангилалаас илүүцийг ол.
 - A. Эд өлгийн
 - B. Бичгийн
 - C. Аман
 - D. Хадны сүг зургийн
3. Эртний хүмүүс өөрсдийн амьдралын тухай мэдээллийг анх юун дээр тэмдэглэсэн бэ??
 - A. Цаас
 - B. Хад
 - C. Модны холтос
 - D. Чулуу
4. Палеолитын үеийн хүмүүсийн онцгой нэгэн чадвар нь чулуугаар зэвсэг хийдэг байв. Багаж зэвсэг хийхэд хамгийн нийцтэй хатуу, амархан эмтэрч бутардаггүй чулуу аль нь вэ?
 - a. Хайрган чулуу
 - b. Өөхөн чулуу
 - c. Цахиур чулуу
 - d. Шаварлаг чулуу
5. Энэ жилийг аргын тооллоор илэрхийлье /1 оноо /
 - a.зуун
6. Чадварлаг хүн гэж нэрлэгдэж хамгийн анх чулуугаар зэвсэг хийсэн гэвэл аль нь вэ?
 - A. Homo habilis
 - B. Homo sapiens
 - C. Homo erectus
 - D. Homo sapiens sapiens
7. Хүмүүс зэрлэг ан амьтдыг гаршуулж, түүнийг аж ахуйдаа ашиглаж эхэлжээ энэ нь аль үед хамаарах вэ?
 - A. Дунд чулуун зэвсгийн үе
 - B. Шинэ чулуун зэвсгийн үе
 - C. Хуучин чулуун зэвсгийн үе
 - D. Хүрэл зэвсгийн үе
8. Дөрвөлжин булш аль үеийн дурсгал вэ?
 - A. Шинэ чулуун зэвсгийн үе
 - B. Хүрэл ба Төмөр зэвсгийн үе
 - C. Төмөр зэвсгийн үе
 - D. Зэс зэвсгийн үе
9. Аль нь хүн төрөлхтний суурин иргэншил үүссэн уугуул нутаг биш вэ?
 - A. Тигр, Евфрат
 - B. Нил
 - C. Амазон
 - D. Шар мөрөн
10. 3,5 сая жилийн өмнө амьдарч байсан хүний яс хаанаас олдсон бэ?
 - a. Африк тивээс олдсон
 - b. Америк тивээс олдсон .
 - c. Австрали тивээс олдсон.
 - d. Ази тивээс олдсон
11. Эртний хүмүүс шавар ваарыг чулуун зэвсгийн аль үед хийж сурсан бэ?
 - a. Хуучин чулуун зэвсгийн үед
 - b. Дунд чулуун зэвсгийн үед
 - c. Шинэ чулуун зэвсгийн үед
 - d. Зэс, чулууны үед
12. НТӨ10000 оны үед дэлхийн хүн ам 4 сая орчим байсан бол НТӨ 5000 он гэхэд 5 сая шахам хүнтэй болжээ. Хүн ам өсөхөд нөлөөлсөн гол хүчин зүйлийг сонгоно уу.
 - A. Гар урлал хөгжсөн.
 - B. Газар тариаланд шилжсэн.
 - C. Мал аж ахуйд шилжсэн.
 - D. Олзворлох, аж ахуй хөгжсөн.
13. Эртний хүмүүс нэг газар удаан хугацаагаар сууршин амьдрах болсон шалтгаан аль нь вэ?
 - a. Газар тариаланд шилжсэнээр
 - b. Гар урлал хөгжсөнөөр

- b. Мал аж ахуйд шилжсэнээр d. Төмөрлөг боловсруулалт хөгжсөнөөр
14. Хүн төрөлхтөн хэзээ үйлдвэрлэх аж ахуйд шилжсэн бэ?
- a. Хуучин чулуун зэвсгийн сүүл үе
 - b. Шинэ чулуун зэвсгийн үе
 - c. Дунд чулуун зэвсгийн үе
 - d. Хүрэл зэвсгийн үе
15. Суурин иргэншилд шилжсэнээр хөдөлмөрийн хуваарьт гарсан өөрчлөлтийг сонгоно уу?
- a. Тариачид тариа ногоогоо, гар урчууд багаж зэвсгээ үйлдвэрлэх болсон .
 - b. Малчид мал аж ахуйгаа, анчид ан гөрөөгөө эрхэлэх болсон .
 - c. Эрэгтэйчүүд ан гөрөө, эмэгтэйчүүд үр жимс түүх болсон.
 - d. Тариачид тариа ногоогоо малчид мал аж ахуйгаа эрхлэх болсон.
16. Анхны бичиг үсэг Шумерт НТӨ 3200-3100 оны үед үүсэн хөгжсөн. Доорхи өгөгдлөөс бичиг үсэг үүссэн шалтгааныг сонгоно уу?
- a. Нүүдэлчид малаа тоолох, бүртгэхийн тулд бий болсон.
 - b. Тариачид ургацаа бүртгэх, хадгалахын тулд үүссэн.
 - c. Хүмүүсийн засаг захиргаа, худалдааны хэргийг тэмдэглэхийн тулд
 - d. Хүмүүс эд хөрөнгөө бүртгэх, хадгалах тооцоолохын тулд
17. Монгол нутагт хэзээ нүүдлийн иргэншил бүрэлдэн бий болсон бэ?
- a. НТӨ IY дэхь мянганы 2-р хагас
 - b. НТӨ Здахь мянганы 2-р хагас
 - c. НТӨ 2дахь мянганы 2-р хагас
 - d. НТӨ 1 дэхь мянганы 2-р хагас
18. Нүүдэлчдийн хүрэл төмөр зэвсгийн үед холбогдох дөрвөлжин булшны дурсгал аль нь вэ?
- a. Эртний хүмүүсийн хад чулуунд зурагласан түүх
 - b. Гонзгой урт чулууг засаж өнгөлсөн хөшөө
 - c. Голдоо овоолсон чулуун дараас бүхий эртний булш
 - d. Хашлага чулуу бүхий оршуулгын байгууламж
19. Эртний Египетүүдийн тахилгын байгууламжийг юу гэдэг вэ?
- a. Пирамид
 - b. Муми
 - c. Сфинкс
 - d. Фараон
20. Хоёр мөрний улсын нийгмийн давхрагыг ажиглаад “хагас чөлөөт иргэд”-ийн давхраанд ямар хүмүүс багтдаг байсныг сонгоно уу?
- a. Түшмэд, тахилч бичээч
 - b. Тариачид, мачид, гар урчууд
 - c. Тахилч, малчид, бичээч
 - d. Тариачид, бичээч, урчууд
21. НТӨ 753 онд эртний Ром хот хаана оршин тогтнож байсан бэ?
- a. Газар дундын тэнгисийн дунд Тибер голын хөвөөнд
 - b. Эгийн тэнгис дэх хойгийн баруун зүүн арлууд
 - c. Газар дундын тэнгисээс эх авсан Ефрат мөрөн
 - d. Эргийн тэнгис дэх хойгийн Олимп ууланд
22. Эртний Хятадын Шан улсад үхрийн далны яс юмуу яст мэлхийний хуяг дээр сайн, муу хүслээ бичиж мэргэ төлөг буулгадаг байсан нь юуг үүсэхэд нөлөөлсөн бэ?
- a. Гар урлал
 - b. Уран зураг
 - c. Гараг судлал
 - d. Бичиг үсэг
23. Эртний Энэтхэгийн Кастын тогтолцоонд хүмүүсийг угсаа гарал нийгэмд эзлэх байр сууриар нь 4 анги буюу кастад хувааж байв. Шудра –д аль давхрагын ямар хүмүүсийг багтааж байсан бэ?
- a. Цэргийн жанжин язгууртнууд
 - b. Тариачид ,урчууд, худалдаачид
 - c. Газаргүй тариачид боолууд
 - d. Санваарттанууд
24. Ойролцоогоор НТӨ онд Инд мөрний хөндийд хүмүүс усалгаат тариалан эрхлэн суурин амьдрах болжээ.
- a. НТӨ 3000
 - b. НТӨ 500 он
 - c. НТӨ 7000
 - d. НТӨ 2300

25. Патрицууд гэдэг тодорхойлолтод аль нь хамаарах вэ?
- Ром хотын суурийг тавьсан язгууртанууд
 - Тариачид малчид урчууд
 - Цэрэг шашны тэргүүнүүд
26. “Эрчүүд нь эмэгтэйчүүдэд хүндэтгэлтэй хандах ёстой ч эмэгтэйчүүд гэртээ эрчүүдийн хүслээр амьдрах ёстой” хэмээн ямар хуульд заасан байдаг вэ?
- Манугийн хууль
 - Хаммурапи хааны хууль
 - 12 Зэс самбарын хууль
 - Их засаг хууль
27. Монгол нутагт байгуулагдсан анхны төрт улс аль нь вэ?
- Хүннү
 - Жужан
 - Сяньби
 - Түрэг
28. Монгол угсааны Сяньби улсыг хэн, хэзээ үндэслэн байгуулсан бэ?
- Бүдүгүнь НТ 141 он
 - Шэлүнь НТ 235 он
 - Таньшихуай НТ 156 он
 - Мугулюй НТ 181 он
29. Орхон голын хөндий Уйгар улс хар балгас хотыг байгуулсан НТ 751 оныг хэддүгээр зуунд хамаархыг олно уу?
- 3-р зуун
 - 4-р зуун
 - 6-р зуун
 - 8-р зуун
30. Монгол нутагт Түрэгийн хаант улсын оршин тогтнож байсан цаг хугацаа аль нь вэ?
- НТ 740-840
 - НТ 840-925
 - НТ 550-740
 - НТ 330-550
31. Хүннүчүүдийн голлох аж ахуй аль нь вэ?
- Нүүдлийн мал аж ахуй
 - Гар үйлдвэрлэл
 - Худалдаа
 - Газар тариалан
32. Монгол нутагт байгуулагдсан Монгол угсааны эртний улсаас хамгийн сүүлд байгуулагдсан улс аль нь вэ?
- Хүннү
 - Сяньби
 - Нирун
 - Хятан
33. Эргүнэ гүнгийн домогт хамаарах өгөгдлөөс бурууг ол
- Түрэгт цохигдсон Жужанчуудын тухай өгүүлнэ
 - Эртний сяньбичуудын түүхийг өгүүлсэн байдаг.
 - Эртний жужан улсын түүх хамаарна .
 - Бөртэ чоно Гуа маралын түүх хамаарна .
34. Хүннү гүрний талаарх ойлголтоос хамааралгүйг нь сонгоно уу.
- Хүннү "амьтны загварт" урлаг өндөр түвшинд хөгжсөн байв.
 - Хүннүгийн оршуулгын дурсгалуудын нэг нь Ноён уулын дурсгал юм.
 - Хүннү гүрний зүүн талд Юэжи, Усуны зэрэг аймгууд оршиж байв.
 - Хүннүгийн үеэс эрийн гурван наадам үүсчээ.
35. Эртний хүмүүсийн хөгжлийн үйл явцыг зөв харгалзуулна уу?
- Ан агнах ургамал түүхэд хэрэглэхийн тулд
 - Ан агнах шинэ газар нутаг хайхын тулд
 - Харилцах шаардлагатай байсан тул
 - Араатнаас биеэ хамгаалж хүнс хоол олж идэхийн тулд
- Хэл зохиов
 - Газар нутагт тархан нүүдэг
 - Багаж зэвсэг хийдэг байв.
 - Овгоороо амьдардаг байв.
- A.1c 2 a 3b 4 d б. 1a 2d 3c 4b в. 1b 2a 3b 4d

36. Доорхийг тохируул

- | | |
|--------------------------|-------------|
| e. Хаммурапи хааны хууль | 1. Энэтхэг |
| f. Муми | 2. Хятад |
| g. Кастийн тогтолцоо | 3. Вавилион |
| h. Цагаан хэрэм | 4. Египет |
| i. Шаантаг бичиг | 5. Шумер |
1. 1a 2d 3b 4c 5e 2. 1c 2d 3a 4b5e 3. 1d 2b3c4a5e

37 Бичиг үсгийн хэлбэрийг зөв харгалзуулна уу.

- | | |
|-----------------|---|
| A. Дүрс бичиг | 1. Финикүүд НТӨ 1200 оны үеэс үсэг зохион хэрэглэх болов. |
| B. Санаа бичиг | 2. Согдоос Монголчууд бичиг үсэг зохиосон. |
| C. Авиан бичиг | 3. Шаантаг хэлбэртэй янз бүрийн тэмдэгт, зургуудыг сийлсэн шавар самбарууд Кунейформ буюу Шаантаг бичиг |
| D. Монгол бичиг | 4. Дүрс нийлүүлж шинэ утга санааг илэрхийлдэг идеограмм |
- A. A 5 B 5 C 2 D3 B. A 4 B 1 C 4 D 1
- C. A 1 B2 C3 D 2 D. A 2 B 3 C 2 D1 E. A3 B4 C 1 D 2

38. Мичин хүний амьдарч байсан цаг хугацааг зөв харгалзуулна уу.

- | | |
|-------------------------|---------------------|
| A. Австралопитек | 1. 100000-одоо |
| B. Homo habilis | 2. 200000-30000 жил |
| C. Homo erectus | 3. 5-1.3 сая жил |
| D. Homo sapiens | 4 . 2,4- 1,6 жил |
| E. Homo sapiens sapiens | 5. 1,5-0,3 сая жил |
- A. A 3 B 4 C 2 D1 E5 B. A 2 B 5 C3 D 4 E 1
- C. A 1 B 3 C 4 D5 E 2 D. A 3 B 4 C 5 D 2 E 1
- E. A 3 B 2 C 1 D4 E 5

39. . Монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн дурсгалыг зөв харгалзуулна уу.

- | | |
|-------------------------|---|
| A. Дөрвөлжин булш | 1. Мал амьтныг “загварчилж” дүрсэлдэг урлагийн чиглэл |
| B. Хиригсүүр | 2. Эртний хүмүүсийн амьдрал ахуйгаа хад чулуунд зураглан бичиглэсэн түүх |
| C. Буган хөшөө | 3. Дөрвөлжин хэлбэрийн хашлага чулуу хашлага бүхий оршуулгын байгууламж |
| D. Хадны зураг | 4. Дөрвөлжин дугуй хүрээ чулуутай, голдоо дугуй чулуун дараас бүхий эртний булш |
| E. Амьтны загварт урлаг | 5. Гонзгой урт чулууг засаж өнгөлөн, дээд хэсэгт нар, сар хөшөөний их биеийг ороолгон бугыг дүрсэлсэн хөшөө |
- A. A 2 B 1 C4 D 1 E3 B. A 4 B 2 C 3 D 4 E5
- C. A 1 B 3 C 2 D 5 E 4 D. A3 B 4 C5 D2 E 1 E. A 5 B 2 C 1 D 3 E2

40. Монголын эртний улсуудыг хаадуудтай нь зөв тохируул

- | | |
|-----------|---------------|
| 1. Хүннү | A. Буман хаан |
| 2. Сяньби | B. Моюунчур |
| 3. Нирун | C. Амбагянь |
| 4. Түрэг | D. Шэлүнь |
| 5. Уйгар | E. Таньшихуай |
| 6. Кидан | F. Модунь |

6-р ангийн бүлгийн сурагч

Авбал зохих оноо

Авсан оноо

Хувь